

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
СҮХБААТАР АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР**

2016 оны үйл ажиллагааны тайлан



**Баруун-Урт хот
2016 он**



ГАРЧИГ

1. Удирдлага зохион байгуулалт	1
2. Санхүүгийн тайлангийн аудит	3
3. Гүйцэтгэлийн аудит	4
4. Нийцлийн аудит	5
5. ИТХ-ын хүсэлтээр болон бусад хийсэн аудит.....	6
6. Дотоод ажил	7
7. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэл	9
8. Дүгнэлт, санал.....	10



УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Үндэсний аудитын газрын харьяа Сүхбаатар аймгийн Аудитын газар нь 2016 онд Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон аудитын олон улсын стандартын хүрээнд үйл ажиллагаагаа явууллаа.

Монгол Улсын Ерөнхий аудитортай байгуулсан “2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөө”-ний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаа. Тодруулбал: Санхүүгийн тайлангийн аудитаар 66 байгууллагад дүгнэлт өгч, 7 гүйцэтгэлийн аудит, 8 нийцлийн аудитыг тус тус амжилттай хэрэгжүүлж ажиллаа.

Сүхбаатар аймгийн Аудитын газар нь дарга, тэргүүлэх аудитор-1, аудитын менежер-1, ахлах аудитор-2, ахлах шинжээч-1, аудитор-2, шинжээч-4, жолооч-1 нийт 12 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна. Бүтэц зохион байгуулалтын хувьд 3 ахлахтай бөгөөд санхүүгийн тайлангийн аудит хариуцсан ахлах аудитор Н.Болдбаатар, гүйцэтгэлийн аудит хариуцсан ахлах аудитор Г.Оюунболд, нийцлийн аудит хариуцсан ахлах шинжээч С.Ариунбаяр нарын шууд удирдлага дор аудитор, шинжээч нар үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хуваарийн дагуу 3 төрлийн аудитыг гүйцэтгэж ажиллаа. Сүхбаатар аймгийн Аудитын газрын ажилтнууд 2016 онд нийт 21,592.0 хүн/цаг ажилласан бөгөөд нэг шинжээч 8 сарын хугацаанд жирэмсэн амаржсаны амралт болон хүүхдээ харах чөлөөтэй байлаа. Ажилласан хүн/цаг-ийг үйл ажиллагааны нэр төрлөөр ангилж авч үзвэл санхүүгийн тайлангийн аудитад 37.4 хувь, гүйцэтгэлийн аудитад 25.1 хувь, нийцлийн аудитад 34.7 хувь, бусад ажилд 2.8 хувийг тус тус зарцуулсан байна.

Тайлант хугацаанд санхүүгийн тайлангийн аудитаар хамрагдвал зохих 240 байгууллагын 7 байгууллагад итгэл үзүүлэн, 167 байгууллагыг түүвэрт хамруулж, 66 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгч, нэгдсэн төлөвлөгөөгөөр 4 гүйцэтгэлийн аудит, 7 нийцлийн аудит, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хүсэлтээр 3 гүйцэтгэлийн аудит, 1 нийцлийн аудитыг тус тус хийж гүйцэтгэсэн байна. Эдгээр аудитыг хийж гүйцэтгэснээр нийт 19,773.2 сая төгрөгийн 213 алдаа, зөрчил илрүүлсэн ба үүнээс 646.0 сая төгрөгийн 42 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 14,988.7 сая төгрөгийн 114 зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж, 4,138.5 сая төгрөгийн 57 алдааг аудитын явцад залруулга хийлгэж, алдаа дутагдлыг арилгах 97 зөвлөмж өгсөн байна. Сүхбаатар аймгийн Аудитын газраас 2016 онд санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай санал дүгнэлт авсан болон хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүйн улмаас материаллаг хэмжээний зөрчил гаргасан 9 албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага тооцуулах саналыг холбогдох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж ажиллаа.

Мөн орон нутгийн төсөвт 2016 онд 148.1 сая төгрөгийн орлого оруулж ажилласан бөгөөд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.4-д заасны дагуу орон нутгийн төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, зардал хямдруулах талаарх саналыг Төсвийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцүүлэн боловсруулан хүргүүлсэн. Үүнд:



- Газрын төлбөрийн орлого нэмэгдэх: Газрын төлбөрийн хэмжээг Газрын төлбөрийн тухай хуулийн 6.3 дах заалт “сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал тогтооно”, Засгийн газрын 1997 оны 152-р тогтоолын 3-р хавсралтыг үндэслэн тогтоон зохих хувь хэмжээний дээд хязгаараар авч үзвэл 98.1 сая төгрөгт хүрч 36.7 сая төгрөгийн орлого нэмэгдэх боломж;
- Цалингийн сан хэмнэх: Засгийн газрын 2011 оны 20 дугаар тогтоол “Сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаар тогтоох”-ын дагуу сумдын Тамгын газрууд 2015-2016 оны байдлаар 64 хүний орон тоо илүү ажиллуулсан байгаа тул бүтэц орон тоог холбогдох тогтоолын дагуу зохион байгуулснаар цалингийн санг 214.5 сая төгрөгөөр хэмнэх боломжтой талаарх саналыг холбогдох тооцоо судалгааны хамт хүргүүлж ажиллаа.

2

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төсвийн тухай хуулийн 8.9, Төрийн аудитын тухай хуулийн 15.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд санхүүгийн тайлангийн аудитыг хугацаанд нь зохих аргачлал, стандартын дагуу үр дүнтэй гүйцэтгэлээ. Санхүүгийн тайлангийн аудитаар улс, орон нутгийн төсвийн байгууллага, сумдын төрийн сан, улс, орон нутгийн өмчийн үйлдвэрийн газар, Төсвийн төвлөрүүлэн захирагчдын нэгтгэл, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангууд, ТЕЗ-ын санхүүгийн тайлангийн нэгтгэл зэрэг 66 санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргасан. Үүнээс 64 байгууллагад “Зөрчилгүй”, 2 байгууллагад “Хязгаарлалттай” санал дүгнэлт өглөө. Харин ТЕЗ-ын харьяаны төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит ААНБ-ууд, төсөл сангуудын нийт 32 санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөр төлөвлөсөнөөс 31 тайланд “Зөрчилгүй”, 1 байгууллагад “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгч ажиллаа.

Санхүүгийн тайлангийн аудитыг хийж гүйцэтгэхтэй холбоотой аудитын өртгийг авч үзвэл цалингийн сан 62.3 сая төгрөг, холбогдох бусад зардалд 3.1 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Мөн түүнчлэн дээрх аудитуудыг хийж гүйцэтгэхэд нийт 1011 хүн/цаг зарцуулан ажиллаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 8,478.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, аудитын явцад 3,845.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүг хугацаанд нь төлж барагдуулаагүй, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан нийт 499.9 сая төгрөгийн акт тогтоож, бүртгэл тайлагналтай холбоотой 1,633.8 сая төгрөгийн зөвлөмж өгч, 2,498.4 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгуулах албан шаардлага өглөө. Санхүүгийн тайлангийн аудитаар 2016 онд нийт 471.2 сая төгрөгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлж ажиллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын журмын 2.4.1-д заасны дагуу 2017 онд санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллага, түүвэрт хамрагдах байгууллага, итгэл үзүүлэх байгууллагын жагсаалтыг гаргаж хүргүүлсэн бөгөөд батлагдсан хуваарийн дагуу СТАУС программд холбогдох мэдээллийг оруулж ажиллаа. Харин санхүүгийн тайлангийн аудитыг 2017 онд 100 хувь дотоод нөөц бололцоогоор хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн бөгөөд хараат бус аудитын компаниар гүйцэтгүүлэхгүй болно.



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Тайлант хугацаанд нэгдсэн төлөвлөгөөгөөр 4 гүйцэтгэлийн аудит хийж гүйцэтгэсэн бөгөөд эдгээр аудитыг хийж гүйцэтгэхтэй холбоотой аудитын өртгийг авч үзвэл цалингийн сан 20.7 сая төгрөг, холбогдох бусад зардалд 2.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Мөн түүнчлэн дээрх аудитуудыг хийж гүйцэтгэхэд нийт 309 хүн/цаг зарцуулан ажиллаа. Дээрх аудитуудаар илэрсэн зөрчлийг арилгуулах 2,124.2 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, холбогдох байгууллага, албан тушаалтанд 8 зөвлөмж өгч ажиллаа. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг товч дурьдвал.

- Монгол Улсын 2015 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл: Төсвийн орлого 2786.5 сая төгрөг буюу 5.7 хувиар тасарсан нь эдийн засгийн хүндрэл үүссэнтэй холбоотой татварын орлого буурсан, төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийг судалгаа, шинжилгээ хийж боловсруулаагүй, түүнд тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн үр дүнгүүд түлхүү нөлөөлсөн байна. Орон нутгийн төсвийн нийт зарлага 45,838.4 сая буюу 93.07 хувийн гүйцэтгэлтэй гарч, өмнөх онтой харьцуулахад 8,806.7 сая төгрөгөөр буюу 16.1 хувиар буурсан байна.
- 2015 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн: 2016 оны Төсвийн тухай хуулиар 6 төсөл арга хэмжээнд 2971,8 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 1552,3 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Орон нутгийн төсвөөс 5 төсөл арга хэмжээнд 2114,2 сая төгрөг баталсан боловч орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө дутуу хуваарилагдсантай холбогдуулан 799,9 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна. ТАХ-г батлахдаа аймаг орон нутгийн үндсэн чиглэлтэй уялдуулаагүй, худалдан авах үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, санхүүжилт дутуу олгогдсоноос гүйцэтгэгч компанитай гэрээний нөхцлүүд дээр маргаан үүссэн зэрэг зөрчил дутагдлууд илэрсэн.
- Улсын нөөцийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт үр дүн: Уг аудитыг холбогдох арга зүй, стандартын дагуу гүйцэтгэж, төлөвлөгөөт хугацаанд нь аудитын тайланг хүргүүлсэн байна. Аудит төрийн нууцтай холбогдож байгаа тул мэдээллийг үр дүнгийн гэрээний биелэлтэд хаалттай үлдээсэн болно.
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэл Сонгуулийн Ерөнхий Хорооноос баталсан төсвийг аргачлал, зөвлөмжийн дагуу аймаг, сумдын сонгуулийн хороодод хуваарилсан боловч зориулалт бус зарцуулан, анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ гаргаж, мөнгөн урамшууллыг илүү бодож олгосон, аймгийн сонгуулийн хороо хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж

ажиллаагүй зэрэг зөрчил дутагдалд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу хариуцлага тооцон, зөрчил арилгах албан шаардлага өгч, хөрөнгийн үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх зөвлөмж хүргүүлэн, бүрэн хэрэгжсэн.

4

НИЙЦЛИЙН АУДИТ

Тайлант хугацаанд нэгдсэн төлөвлөгөөгөөр 7 нийцлийн аудит хийж гүйцэтгэсэн бөгөөд эдгээр аудитыг хийж гүйцэтгэхтэй холбоотой аудитын өртгийг авч үзвэл цалингийн сан 46.4 сая төгрөг, холбогдох бусад зардалд 4.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Мөн түүнчлэн дээрх аудитуудыг хийж гүйцэтгэхэд нийт 789 хүн/цаг зарцуулан ажиллаа. Нэгдсэн төлөвлөгөөгөөр хийсэн дээрх аудитуудаар 22.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгуулах 953.9 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, холбогдох байгууллага, албан тушаалтанд 19 зөвлөмж өгч ажиллаа. Нэгдсэн төлөвлөгөөгөөр хийсэн дээрх 7 аудитаар нийт 13.3 сая төгрөгийн үр өгөөжийг холбогдох байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж ажиллаа. Нийцлийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг товч дурьдвал.

- Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт: Аймгийн ОНХС-ийн төлөвлөлтийг хууль тогтоомжийн дагуу боловсруулсан боловч ихэнх сумд ОНХС-г төлөвлөөгүй, орлогын шилжүүлгийг хуульд заасан харьцаагаар хуваарилаагүй, ИНХ-аар дэмжигдээгүй төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн, БАҮ-г хүлээн авах комисс эрх, үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн, захиалагчийн хяналтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй зэрэг зөрчил дутагдлууд илэрсэн. Мөн материаллаг зөрчил гаргасан холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах саналыг харьяа дээд шатны байгууллагуудад нь хүргүүллээ.
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт: Аудитын явцад Шилэн дансны тухай хуульд заасан бүх төрлийн мэдээллийг хэрхэн байршуулахыг харуулсан үлгэрчилсэн жишээ цэс нэмэлтээр бий болгох нь хууль хэрэгжүүлэгч нарт ойлгомжтой болох тухай саналыг Сангийн яам болон шилэн дансны нэгдсэн цахим системийг хөгжүүлэгч компанид хүргүүлсэн. Тус аудитаар зөрчил арилгуулах 16 албан шаардлага, 4 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал, 6 төрлийн зөвлөмж хүргүүлж ажилласан бөгөөд албан шаардлага бүрэн хэрэгжиж, зөвлөмж хэрэгжих шатандаа байна.
- Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн: Сумдын Төсвийн захирагч нар БХС-ийн хөрөнгийг төлөвлөж, ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулалгүй, хууль зөрчин дур мэдэн зарцуулдаг, гэрээний хэрэгжилтийг дүгнэдэггүй, хөрөнгийн зарцуулалтанд тавих дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй, хяналт шалгалт тогтмол хийгдэггүй зэрэг зөрчлүүд аудитаар тогтоогдлоо.
- Орон нутгийн хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэлд хийх аудит: Аймгийн Сонгуулийн хороо улсын төсвөөс сонгуулийн зардалд хуваарилагдаж ирсэн 247.1 сая төгрөгөөс 233.3 сая төгрөгийг зарцуулж 13.8 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.
- Сонгуулийн мөрийн хөтөлбөрт хийх аудит: Аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуульд оролцох 6 нам, 2 бие даан нэр дэвшигч мөрийн хөтөлбөрөө ирүүлсэнд

хуулийн дагуу холбогдох шалгуурыг үндэслэн аудитыг гүйцэтгэж, 5 албан шаардлага өгч мөрийн хөтөлбөрт залруулга хийлгэсэн. Сумдын ИТХ-ын сонгуульд оролцох 3 нам мөрийн хөтөлбөрөө ирүүлсэнд хуулийн дагуу холбогдох шалгуурыг үндэслэн аудитыг гүйцэтгэж, 17 мөрийн хөтөлбөрт залруулга хийлгэж, 2 албан шаардлага өгч ажиллаа.

- Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хийх аудит: Аудитаар Сүхбаатар, Дарьганга сумын ЗДТГ-аас хадлангийн зориулалтаар олгосон газрын төлбөрийг төсөвт төвлөрүүлээгүй 10314.8 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож орон нутгийн төсөвт 6.4 сая төгрөг төвлөрөөд байна. Байгаль орчин аялал жуулчлалын газар нь Онгон, Баяндэлгэр сумын нутагт “Ойн зурвас байгуулах” ажлыг гүйцэтгүүлэхээр “Онгон-Арвижих” ОНӨААТҮГ, “Талын жимс” ТББ-тай гэрээ байгуулан санхүүжилтийг бүрэн олгосон боловч ургалт хангалтгүй, суулгацын амьдралт зохих түвшинд хүрээгүй тул 12.0 сая төгрөгийн албан шаардлага өгч, хэрэгжсэн.



ИТХ-ЫН ХҮСЭЛТЭЭР БОЛОН БУСАД ХИЙСЭН АУДИТЫН ТАЛААР

Тайлант хугацаанд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хүсэлтээр 3 гүйцэтгэлийн аудит, 1 нийцлийн аудит хийж гүйцэтгэсэн бөгөөд эдгээр аудитыг хийж гүйцэтгэхтэй холбоотой аудитын өртгийг авч үзвэл цалингийн сан 31.2 сая төгрөг, холбогдох бусад зардалд 2.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Мөн түүнчлэн дээрх аудитуудыг хийж гүйцэтгэхэд нийт 518 хүн/цаг зарцуулан ажиллаа. Аймгийн ИТХ-ын хүсэлтээр хийсэн дээрх аудитуудаар 155.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгуулах 8,706.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, холбогдох байгууллага, албан тушаалтанд 21 зөвлөмж өгч ажиллаа. Аймгийн ИТХ-ын хүсэлтээр хийсэн дээрх 4 аудитаар нийт 261.9 сая төгрөгийн үр өгөөжийг холбогдох байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж ажиллаа. Аймгийн ИТХ-ын хүсэлтээр хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг товч дурьдвал.

- “Хун Ша И Жань” ХХК-ний улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогын бүрдүүлэлт, тайлагнал: Аудитаар орон нутгийн төсөвт төвлөрөх 74,8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах 7794,7 сая төгрөгийн албан шаардлага өгч, бүрэн хэрэгжсэн. Мөн шалгагдагч байгууллагын ажилчдаас гаргасан өргөдөл гомдлыг хүлээн авч, ажлын нөхцөл сайжруулах, зарим асуудлыг аудитын хугацаанд шийдвэрлүүлж, бусад санал хүсэлтийг шийдвэрлэх талаар зөвлөмж хүргүүлж, биелэлтийг хангууллаа.
- “Дөрвөлж” ОНӨҮГ-ын 2014, 2015 оны үйл ажиллагааны үр дүн: Аудитаар 811.5 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж 20.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 509.3 сая төгрөгийн албан шаардлага, 281.6 сая төгрөгийн зөвлөмж өгч, хэрэгжих шатандаа байна. Мөн 126.8 сая төгрөгийн үр өгөөж тооцож шалгагдагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж бүртгэлээ. Орон нутгийн удирдлагын шийдвэрээр Боловсрол хорооллын 186 айлын орон сууцны БУА-ын төсөвт өртөгт салбар шугам сүлжээний өртөгийг тооцоогүйгээс алдагдал хүлээсэн, шугамын



усны алдагдлыг багасгахаар бодит ажил зохион байгуулаагүй, ТУЗ татан буугдсантай холбоотой борлуулалт удирдлагын зардал өссөн, өглөг авлагын зохистой харьцаа алдагдаж, иргэн хувь хүнээс өндөр хүүтэй зээл авч үр ашиггүй үрэлгэн зарцуулалт гаргасан байдлыг аудитаар тогтоолоо.

- “Сүхбаатар тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ-ын 2015 оны үйл ажиллагааны үр дүн: Тус аудитаар тээвэр шатахууныг норм нормативаар бодож олгоогүй, зарцуулалтад тавих хяналт сул, айл өрхийн хог хаягдлын төлбөрийн орлогыг сар бүр тооцоо нийлж баталгаажуулдаггүй, авлагыг тайланд дутуу илэрхийлсэн, өмч хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэргүй шилжүүлсэн, түрээсийн орлогыг төвлөрүүлээгүй, материал бэлтгэхдээ хувийн харилцах данс ашигладаг зэрэг зөрчил дутагдлууд илэрсэн.
- “Сүм хөгжүүлэх сан”-ын 2014, 2015 оны зээлийн эргэн төлөлт, төслийн хэрэгжилтийн үр дүн: Тус аудитаар төсөл сонгон шалгаруулах комисс эрх үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн, сумдын ИТХ-аас тавих хяналт үр дүнгүй, зээлүүд гэрээнд заасан хугацаандаа төвлөрөөгүй, төсөл хөтөлбөрүүд зориулалтын дагуу хэрэгжээгүй, хөрөнгийг зориулалт бус зарцуулсан, СХС-ийн зээлийн хөрөнгийг НББ-ээр зөрүүтэй илэрхийлсэн зөрчил дутагдлууд аудитаар тогтоогдсон.

6

ДОТООД АЖИЛ

Сүхбаатар аймгийн Аудитын газар нь www.audit.mn веб сайтаар 2016 оны эхний хагас жилд хийсэн бүх аудитын дүн, дүгнэлтийг хураангуйлан байршуулж, олон нийтэд цахимаар түгээлээ. Үндэсний аудитын газраас 2014 онд нэвтрүүлж эхэлсэн Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем (СТАУС) программыг 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитад бүрэн ашиглаж, аудитыг стандарт, журам, гарын авлагын дагуу гүйцэтгэлээ. Мөн аймгийн Аудитын газрын албан тушаалтнуудаас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан авч, холбогдох тайланг хуульд заасны дагуу 02 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт хүргүүлж ажиллаа.

Сүхбаатар аймгийн Аудитын газарт тайлант онд иргэдээс 3 өргөдөл, цагдаагийн байгууллагаас 2 “Шинжилгээ хийлгэх тогтоол” ирүүлсэнийг хуулийн хугацаанд шалган хариуг албан бичгээр хүргүүллээ. Архив, бичиг хэрэг хөтлөлтийг стандартын дагуу хөтлөсөн бөгөөд ирсэн 379 албан бичгийн бүртгэлтэй танилцан, хугацаатай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж, 226 албан бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж ажиллаа. Мөн Үндэсний аудитын газраас өгсөн чиглэлийн дагуу байгууллагын өрөө тасалгааны нөөц боломжийг дайчлах замаар вакуман хийцтэй тусгаарлах хана хийлгүүлж архив, бичиг хэрэг, нууцын ажил хариуцсан шинжээчийг тусгай өрөөтэй болголоо. Орон нутагт зохион байгуулагдаж байгаа хог цэвэрлэгээ, мод тарих, нийтийн биеийн тамир, хууль эрх зүйн сургалт сурталчилгаа зэрэг олон нийтийн ажилд тухай бүр нь хамт олноороо идэвхитэй оролцлоо.



Төрийн аудитын байгууллагын ажилтны мэргэжлийн тасралтгүй сургалтын журмын дагуу манай байгууллага дотооддоо мэргэжлийн тасралтгүй боловсролын хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаа. Мэргэжлийн түвшин тогтоох шалгалтанд 5 жил ажилласан 3 ажилтан, 10 жил ажилласан 1 ажилтан хамрагдаж 85 дээш хувийн амжилттай шалгагдлаа.

Үндэсний аудитын газраас 2016 оны 03-р сарын 13-ны өдөр Сүхбаатар аймагт зохион байгуулсан “Аудитын олон улсын стандартын хэрэглээ” сэдэвт сургалтад Сүхбаатар аймгийн аудитын газрын аудитор, шинжээч нар амжилттай хамрагдлаа. Мөн түүнчлэн 2016 оны 06-р сарын 22-ны өдөр зохион байгуулагдсан “Аудитад мэдээллийн технологийг ашиглах, хөгжүүлэх зарим асуудал” сэдэвт хэлэлцүүлэгт Сүхбаатар аймгийн аудитын газар 6 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо.

Авлигын эсрэг үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөөг 2016 оны 03-р сарын 10 - ны өдөр баталсан бөгөөд төлөвлөгөөний дагуу мэргэжлийн тасралтгүй боловсролын дотоод сургалтаар “Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм”, “Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай”, “Үндэсний аудитын газрын нууц хамгаалах журам” сэдвээр нийт 3 цагийн хичээлийг ажилтан албан хаагчдад заалаа. Мөн ҮАГ-аас мэдээлэл технологийн ажилтнуудад зориулсан сургалтанд шинжээч Б.Мөнхбамбар хамрагдсан бөгөөд “Нууц баримт бичгийн тухай, Байгууллагын нууцын тухай, Төрийн нууцын ажилтны томилсон тушаал танилцуулах, арга зүйн зөвлөгөө өгөх”, “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай”, “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” сэдвээр ажилтан албан хаагчдад хичээл заалаа. Авлигатай тэмцэх газрын соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтнууд 11 сард аймагт ажиллаж, 5 хоногийн сургалт зохион байгуулахад бүх аудитор, шинжээч нар хамрагдав.

Баруун-Урт хотод болсон МНБ-ын эрх авах сургалт, шалгалтанд шинжээч Э.Алтансүх, Авилгатай тэмцэх газраас зохион байгуулсан хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч нарт зориулсан сургалт, Сангийн яамнаас зохион байгуулсан “Шилэн дансны тухай” хуулийн сургалтанд байгууллагын ажилтнууд 100 хувь, ММНБ-ын институтээс зохион байгуулсан “Мэргэшсэн нягтлан бодогчийн ёс зүй” сэдэвт 20 кредитийн сургалтанд аудитын менежер Г.Даваа, ахлах аудитор Н.Болдбаатар, Г.Оюунболд, аудитор О.Барчидгүнсэн, А.Мөнхцэцэг нар хамрагдсан ба ажилтнууд бие даан англи хэл, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлж байна. Гавъяат эдийн засагч З.Нямын нэрэмжит нягтлан бодох бүртгэлийн зүүн бүсийн “Олимпиад”-д шинжээч Э.Алтансүх тэргүүн байр эзэллээ.

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан болон статистик мэдээг боловсруулж тайлагнах журмын дагуу бүртгэл, нэгтгэл, статистик мэдээний маягтыг хөтлөх ажиллагааг хөнгөвчилөх зорилгоор MS Excel программ дээр өөр хоорондоо уялдаа холбоотой үзүүлэлтүүдийг нөхцөлт томъёогоор холболт хийж мэдээ гаргах үйл ажиллагаандаа ашиглаж байна.

7

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Санхүүгийн тайланг УСНББОУС, НББ-ийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад заавар журамд заасны дагуу цаг хугацаанд нь үнэн зөв тайлагнан ҮАГ-т хүргүүлэн ажиллаж байна. Тухайлбал 2015 оны санхүүгийн тайланг Мэдээлэл аудит ХХК-иар аудитлуулсан бөгөөд "Зөрчилгүй санал" дүгнэлт авч ажиллаа.

Нягтлан бодох бүртгэлийн ажил гүйлгээг хийж гүйцэтгэхдээ Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг чанд мөрдөн ажиллаж байна. Түүнчлэн төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн бусад мэдээ мэдээллийг "Мэдээллийн ил тод байдлын самбар"-т тухай бүр байршуулахын зэрэгцээ шилэн дансны нэгдсэн портал сайтад хуульд заасан хугацаанд байршуулан ажиллаж байна. Батлагдсан төсөв 246,873.9 мянган төгрөг гүйцэтгэлээр 246807.2 мянган төгрөгийн санхүүжилт авч 244572.6 мянган төгрөгийн гүйцэтгэл гарч 2234.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Батлагдсан төсөвт багтаан өр, авлага үүсгэлгүй ажиллаж байна.

Байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээг дараа сарын 2-ны дотор, хагас жилийн тайланг дараа сарын 20-ны дотор дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллаа. Байгууллагын санхүүгийн мэдээллийг хуулийн хугацаанд Шилэн дансны нэгдсэн вэб сайт болон Үндэсний аудитын газрын вэб сайт, байгууллагын ил тод байдлын самбарт тогтмол мэдээлж байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон ҮАГ-ын цахим хуудсанд 2016 оны төсвийн хуваарь, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт сар улирал бүр, 2015 оны санхүүгийн тайлан, 2016 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, 2017 оны төсвийн төсөл, 2015 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт зэрэг 131 төрлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулж ажиллаа. Төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу 2017 оны төсвийн төслийг боловсруулсан бөгөөд нягтлан бодогчийн хийсэн судалгаагаар 2017 онд нийт 267.8 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэж тооцоолсон байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2.1 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн "Эд хөрөнгийн тооллогын комисс томилох тухай 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/20 тоот тушаал гаргаж, 3 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс эд хөрөнгийг 2016.12.21-ний өдөр тоолж дуусгасан бөгөөд тооллогыг дүнг баталгаажуулж ажиллаа. Мөнгөн хөрөнгө, бараа материалын орлого, зарлагын гүйлгээний баримтын дугаар, үйлдсэн зөвшөөрсөн ажилтны гарын үсэг, тамга тэмдгийн бүрдэлд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

8

ДҮГНЭЛТ, САНАЛ

Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу 2016 онд санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай санал дүгнэлт авсан болон хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүйн улмаас гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг хэмжээний зөрчил гаргасан 9 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлагыг холбогдох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэнээс 4 албан хаагчид хариуцлага тооцсон тухай албан бичиг ирүүлсэн бөгөөд хариуцлага тооцох 5 албан шаардлагын хугацаа нь болоогүй байна.

Тайлант хугацаанд санхүүгийн тайлангийн аудитаар 167 байгууллагыг түүвэрт хамруулж, 66 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгч, нэгдсэн төлөвлөгөө болон аймгийн ИТХ-ын хүсэлтээр 7 гүйцэтгэлийн аудит, 8 нийцлийн аудитыг тус тус хийж гүйцэтгэсэн байна. Эдгээр аудитаар тогтоосон акт, хүргүүлсэн албан шаардлага, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал.

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Тайлант оны дүн		Хэрэгжилт		Хэрэгжилтийн хувь
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	
1	Акт	42	646	18	594.5	92.0
2	Албан шаардлага	114	14988.7	75	11559.8	77.1
3	Зөвлөмж	97		58		59.8

Тайлант онд нийт 746.4 сая төгрөгийн үр өгөөж харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.НАРАНТУЯА